



Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4 дүгээр хавсралт

УВС ХҮНС ХК-ийн 2022 оны хагас жилийн үйл ажиллагааны тайлан

| | |
|--|--|
| Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлан /маягт 2/ | |
| <i>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</i> | |
| <i>Тайлагнах хугацаа</i> | 2022 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдөр |
| <i>Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар</i> | Компанийн нэр: УВС ХҮНС ХУВЬЦААТ КОМПАНИ УБГД:1510001008, РД:2001969 Үнэт цаасны код: HUN Хаяг: Увс аймаг, Улаангом сум, 5-р баг Утас: 75558686 И-мэйл: info@uvfoods.mn Пэйж: Увс Хүнс ХК/Uvs Foods JSC |
| <i>Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр</i> | Монголын хөрөнгийн бирж |
| <i>Бизнесийн үйл ажиллагааны салбар</i> | Хүнс үйлдвэрлэл, газар тариалан |
| <i>Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг</i> | 112,716 ширхэг |
| <i>Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр</i> | Хагас жилийн тайланг бэлтгэсэн: Маркетинг, борлуулалтын албаны дарга Э.Батзаяа, Хянасан: Гүйцэтгэх захирал Л.Нямгэрэл |
| 1. | <i>Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан / Хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</i> |

| | | мян.төг | |
|------------------------------------|--|-------------|-------------|
| | Үзүүлэлт | 2021.12.31 | 2022.06.30 |
| <i>Санхүүгийн байдлын үзүүлэлт</i> | Хөрөнгө | | |
| | Эргэлтийн хөрөнгө | 3,476,547.0 | 2,523,812.2 |
| | Эргэлтийн бус хөрөнгө | 1,573,540.4 | 1,509,687.4 |
| | Нийт хөрөнгө | 5,050,087.4 | 4,033,499.6 |
| | Өр төлбөр ба эздийн өмч | | |
| | Богино хугацаат өр төлбөр | 1,732,908.3 | 656,793.9 |
| | Урт хугацаат өр төлбөр | 950,000.0 | 849,999.8 |
| | Эздийн өмч | 2,367,179.0 | 2,526,705.9 |
| | Нийт өр төлбөр ба эздийн өмч | 5,050,087.4 | 4,033,499.6 |
| <i>Орлогын тайлан</i> | Үзүүлэлт | 2021.12.31 | 2022.06. 0 |
| | Борлуулалтын орлого | 4179403.6 | 1,812,241.1 |
| | Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 3,011,256.0 | 1,062,278.7 |
| | Нийт ашиг | 1,168,147.6 | 749,962.4 |
| | Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал | 225794.7 | 177907.7 |
| | Орлогын албан татварын зардал | 23217.8 | 18,380.8 |
| | Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал | 202576.9 | 159,526.9 |
| <i>Өмчийн өөрчлөлтийн тайлан</i> | Үзүүлэлт | 2021.12.31 | 2022.06.30 |
| | Энгийн хувьцаа | 14736.7 | 14,736.7 |
| | Дахин үнэлгээний нэмэгдэл | 847420.5 | 847,420.5 |
| | Хуримтлагдсан ашиг | 1505021.8 | 1,664,548.7 |
| | Нийт эздийн өмчийн дүн | ,367,179.0 | 2,526,705.9 |
| <i>Мөнгөн гүйлгээний тайлан</i> | Үзүүлэлт | 2021.12.31 | 2022.06.30 |
| | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 93,815.7 | (496,978.0) |
| | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (2,800.0) | - |
| | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 450,000.0 | (100,000.2) |
| | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | 541,015.7 | (596,978.2) |
| | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 118,985.5 | 660,001.2 |

| | | | | |
|--|--|---|-----------|----------|
| | | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 660,001.2 | 63,023.1 |
| 2. | <i>Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт</i> | | | |
| ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж дүгнэлт гаргадаг. Хагас жилийн тайланг хэлэлцэж батлаагүй. | | | | |
| 3. | <i>Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан дүгнэлт</i> | | | |
| 3.1 | <i>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</i> | Нийт ашгийн хувь | 28.0% | 41.4 |
| | | Үйл ажиллагааны ашгийн хувь | 5.4% | 9.8% |
| | | Цэвэр ашгийн хувь | 4.8% | 8.8% |
| | | Өөрийн хөрөнгийн өгөөж | 8.6% | 6.3% |
| 3.2 | <i>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</i> | Эргэлтийн харьцаа | 2.0 | 3.8 |
| | | Түргэн хөрвөх чадварын харьцаа | 1.13 | 1.39 |
| | | Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа | 1.13 | .60 |
| | | Бараа материалын эргэц | 2.50 | 0.68 |
| 3.3 | <i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүний үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөнд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл</i> | Ковид -19 цар тахал, хил гаалийн үйл ажиллагаа, валютын ханшны өөрчлөлтөөс хамаарч түүхий эд материалын үнэ өсөх, бэлэн бүтээгдэхүүний өртөг нэмэгдэх өөрчлөлтүүд гарч байна. Өөрчлөлтийн эсрэг: <ul style="list-style-type: none"> - Валютын хэлцэл арилжааны банкуудтай хийх - Түүхий эд материал тасалдах эрсдлээс сэргийлж боломжит арга хэмжээг авах, урьдчилж захиалга хийх - Бүтээгдэхүүний өртөг, үнэ, борлуулалтын зорилт, төлөвлөгөө, мөнгөн урсгалд хяналт тавих - Чацарганы бүтээгдэхүүнийг экспортонд гаргахын тулд Европын холбоонд “Увсын чацаргана” газар зүйн заалтыг бүртгүүлэх, брэндбүүк хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэлээ. | | |
| 3.4 | <i>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого</i> | Санхүүгийн байдлын гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй. | | |
| 4 | <i>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго,</i> | | | |

| | |
|----|--|
| | <i>сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл / тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</i> |
| | <i>Их хэмжээний хэлцэл: Тайлангийн хугацаанд их хэмжээний хэлцэл, холбоотой талуудтай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй болно.</i> |
| | |
| 5. | <i>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл</i> |
| | <i>Тайлант хугацаанд олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.</i> |
| 5. | <i>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</i> |
| | <p style="text-align: center;">Хувьцаа эзэмшигчдийн хурал</p> <p>“УВС ХҮНС” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр Увс аймаг Улаангом сум 5-р баг “УВС ХҮНС” ХК-ийн байр хурлын өрөөнд хуралдан дараах шийдвэрүүдийг гаргав. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. “УВС ХҮНС” ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг дүгнэн батлав. 2. “УВС ХҮНС” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн батлав. 3. “УВС ХҮНС” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг улируулан сонгов. <p>“УВС ХҮНС” Хувцаат Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Ердийн гишүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Л.Мөнхнаран - Т.Лхагвасүрэн - Л.Нямгэрэл - Л.Мөнхтуяа - Л.Энхтуяа - Л.Батмөнх <p>“УВС ХҮНС” ХК-ийн Хувцаат Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хараат бус гишүүд:</p> <ul style="list-style-type: none"> - А.Чимэд-Очир - Ж.Бааст - Н.Оюун |
| 6. | <i>Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл</i> |
| | <p style="text-align: center;">Компанийн засаглалын кодекс:</p> <p>“Санхүүгийн зохицуулах хороо”-ны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн №145 тоот тогтоолоор “Компанийн засаглалын кодекс” шинэчлэн батлагдсан дагуу дүрэм журмуудыг шинэчлэн батлахаар тусгав.</p> <ol style="list-style-type: none"> 1. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны журам шинэчлэх 2. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хорооны журам шинэчлэх 3. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны журам шинэчлэх 4. ТУЗ-ийн дэргэдэх эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам батлах 5. ТУЗ-ийн ёсзүйн дүрэм батлах |

| | 6. Залгамж халааны журам боловсруулах | | | | | | | | | | | | |
|----------------------------|--|------------|------------|--------------------|------------|----------------------|-----------|------------------------|-------------|-----------|----|----------|----|
| 7. | Үйл ажиллагаатай холбоотой бусад нэмэлт мэдээлэл | | | | | | | | | | | | |
| Борлуулалт, цэвэр ашиг | <table border="1"> <caption>Борлуулалт, цэвэр ашиг (мян.төг)</caption> <thead> <tr> <th>Тариал</th> <th>Борлуулалт</th> <th>Цэвэр ашиг</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>2021.12.31</td> <td>4,179,403.6</td> <td>202,576.9</td> </tr> <tr> <td>2022.06.30</td> <td>1,812,241.1</td> <td>159,526.9</td> </tr> </tbody> </table> | Тариал | Борлуулалт | Цэвэр ашиг | 2021.12.31 | 4,179,403.6 | 202,576.9 | 2022.06.30 | 1,812,241.1 | 159,526.9 | | | |
| Тариал | Борлуулалт | Цэвэр ашиг | | | | | | | | | | | |
| 2021.12.31 | 4,179,403.6 | 202,576.9 | | | | | | | | | | | |
| 2022.06.30 | 1,812,241.1 | 159,526.9 | | | | | | | | | | | |
| Борлуулалтын орлого, бүтэц | <table border="1"> <caption>Борлуулалтын бүтэц (%)</caption> <thead> <tr> <th>Бүтэц</th> <th>Хувь</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Архин бүтээгдэхүүн</td> <td>33%</td> </tr> <tr> <td>Гурилан бүтээгдэхүүн</td> <td>31%</td> </tr> <tr> <td>Чацарганы бүтээгдэхүүн</td> <td>24%</td> </tr> <tr> <td>Бусад</td> <td>9%</td> </tr> <tr> <td>Цэвэр ус</td> <td>3%</td> </tr> </tbody> </table> | Бүтэц | Хувь | Архин бүтээгдэхүүн | 33% | Гурилан бүтээгдэхүүн | 31% | Чацарганы бүтээгдэхүүн | 24% | Бусад | 9% | Цэвэр ус | 3% |
| Бүтэц | Хувь | | | | | | | | | | | | |
| Архин бүтээгдэхүүн | 33% | | | | | | | | | | | | |
| Гурилан бүтээгдэхүүн | 31% | | | | | | | | | | | | |
| Чацарганы бүтээгдэхүүн | 24% | | | | | | | | | | | | |
| Бусад | 9% | | | | | | | | | | | | |
| Цэвэр ус | 3% | | | | | | | | | | | | |
| Бүтээгдэхүүн хөгжүүлэлт | Талх, нарийн боов: Нарийн боовны 50 гаруй, талхны 10 гаруй, 3 төрлийн жигнэмэг, кекс, пирог үйлдвэрлэж байна. “Улаангом” жигнэмэгний савлагаа шинэчлэгдэж, “Эвэл” тавгийн боорцог шинээр худалдаанд гарсан. | | | | | | | | | | | | |



Гурилан бүтээгдэхүүний амталгаат худалдаа 2022 оны 05 дугаар сарын 30-нд зохион байгуулав.



Чацарганы бүтээгдэхүүн: “Увсын чацаргана” өтгөрүүлсэн шүүс 35 мл, 500 мл, 5 л савлагаатай,



чацарганы цэвэр болон үрийн тос 50 мл, 100 мл



чацарганы болон үхрийн нүдний чанамал 240 мл, цайны бэлдэц 50 г савлагаагаар үйлдвэрлэж байна.

Германы SGS лабораторын шинжилгээгээр Чацарганы цэвэр болон үрийн тосонд К, Е витамин, Каротинойд, Омега 3, 6 микроэлементүүд өндөр гарсан нь “Увсын чацаргана” газар зүйн заалттай бүтээгдэхүүн чанартай бүтээгдэхүүн болохоо харуулж байна.

| Шим тэжээлийн үзүүлэлт | Шинжилгээний арга | Чацарганы цэвэр тос | Чацарганы үрийн тос |
|------------------------|-------------------|---------------------|---------------------|
| Витамин К | HPLC | 165мг/гр | 1230мг/гр |
| Витамин Е | HPLC | 198мг/гр | 175мг/гр |
| Каротинойд | HPLC | 325мг/гр | 68,15мг/гр |
| Омега 3 | HPLC | 0,92% | 34,53% |
| Омега 6 | HPLC | 14,62% | 35,58% |
| Пальмитины хүчил | HPLC | 32,68% | 8,52% |
| Палмитолийн хүчил | HPLC | 36,07% | 1,94% |
| Стериний хүчил | HPLC | 1,21% | 2,35% |
| Олейны хүчил | HPLC | 11,53% | 15,47% |
| Линолын хүчил | HPLC | 14,62% | 35,58% |
| Линолейны хүчил | HPLC | 34,53% | 34,53% |
| Арахидоны хүчил | HPLC | 0,92% | 0,35% |
| Веникий хүчил | HPLC | 0,32% | 0,09% |


Сүү, сүүн бүтээгдэхүүн: Ааруул, бяслаг, шар тос, цөцгий, тараг, шар сүү, цагаан идээний бэлгийн багц худалдаанд гарсан.



Цөцгийтэй, гүзээлгэнэтэй, ногоон цайтай, шоколадтай, тарагтай сүүн зайрмаг худалдаанд гарлаа.



| | | |
|--|---|---|
| | | <p>Цэвэр ус: “Улаангом” нэрийн 500 мл, 1,5 л, 5 л, 18,9 л цэвэр ус үйлдвэрлэдэг. 18,9 л цэвэр усны түгээлтийн 2 зэрэг хийснээр хэрэглэгчийн хүлээлтэнд хүрсэн үйлчилгээ боллоо.</p>  <p>Гурил: Жилд 300-700 тн улаанбуудай бэлтгэн “Баянцагаан” нэрийн 5 кг, 10 кг, 25 кг, 50 кг савлагааны дээд гурил, 2-р зэргийн гурил, 25 кг савлагааны хивэг үйлдвэрлэж байна.</p> |
| | <p><i>Facebook платформ</i></p> | <p>Увс Хүнс ХК/Uvs Foods JSC пэйж хуудасны хүртээмж 69,252 хүн, 3,535 хүн зочилсон, шинэ лайке 604 хүн, 104 цахим хүсэлт ирж холбогдох зөвлөгөө, хариулт авсан.</p> |
| | <p><i>Хэрэглэгч, харилцагчийн үйлчилгээ</i></p> | <p>Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг тасралтгүй нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний хөгжүүлэлт, чанарын бодлого, зорилтын хэмжилт хийж, үнэлэлт, дүгнэлт хийдэг. Онлайн судалгаа: I улиралд чацарганы цэвэр болон үрийн тосны судалгаа 93,8 хувь, II улиралд чацарганатай бүтээгдэхүүний бэлгийн багцын судалгаа 88,2 хувийн сэтгэл ханамжтай үнэлгээ авсан байна.</p> |
| | <p><i>Нэгдсэн удирдлагын тогтолцоо</i></p> | <p>2018 оноос олон улсын чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 стандарт, хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 22000:2018 стандартуудыг хэрэгжүүлэн жил бүр хяналтын болон магадлан аудитыг амжилттай хийлгүүлэн ажиллаж байна.</p> |

| | | |
|--|--|---|
| | |  <p>CERTIFICATE</p> <p>This is to certify that</p> <p>Uvs Foods JSC Uvs Khums LLC building, 5th bag 85160, Ulaangom soum Uvs province Mongolia</p> <p>has implemented and maintains a Quality Management System</p> <p>Scope: Processing and manufacturing of seabuckthorn juice, seabuckthorn seed oil, seabuckthorn pulp oil</p> <p>Through an audit, documented in a report, it was verified that the management system fulfills the requirements of the following standard:</p> <p>ISO 9001 : 2015</p> <p>Certificate registration no. 31101762 QM15 Valid from 2020-02-04 Valid until 2023-02-03 Date of certification 2020-02-04</p> <p>DQS GmbH Markus Beyer Managing Director</p> <p>Accredited Body: DQS GmbH, August-Straße 21, 60433 Frankfurt am Main, Germany Administration Office: DQS (USA) GmbH, Reservoir Road, #1000, Yonkers, New York, USA</p> <p>PECB MS BEYOND RECOGNITION</p> <p>CERTIFICATE</p> <p>PECB MS hereby certifies that the management system of</p> <p>Uvs Foods JSC Uvs foods factory building, 5th bag, 85160 Ulaangom soum, Uvs province, Mongolia</p> <p>Has been assessed and found to be in accordance with the management system requirements in</p> <p>ISO 22000:2018</p> <p>Certification Scope: Production and sales of the condensed seabuckthorn juice and the seabuckthorn oil</p> <p>Certificate No. 0954-FSMS16-09-20-issue2 Certified since 2020-09-22 Valid from 2021-11-02 until 2023-09-21</p> <p><i>Nick Handzsi</i> Nick Handzsi Senior Business & Operations Director</p> <p>*Subject to annual surveillance audits This certificate can be validated by email request at: ms@pecb-ms.com www.pecb-ms.com</p> <p>PECB MS 1555 Road de l'Éclair, Toronto, ON L4W 1Y5, Canada +1 416 425 1522</p> |
| | <p><i>Эрсдэл, дотоод аудит</i></p> | <p>Дотоод аудитын хөтөлбөрийн дагуу жилд 2 удаа аудитын төлөвлөгөө боловсруулан үйлдвэрийн нэгж, албадуудад дотоод аудит хийдэг. Эрсдлийн бүртгэл, эрсдлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний дагуу төлөвлөсөн арга хэмжээний хэмжилтүүдийг хийж, удирдлагын дүн шинжилгээний хуралаар чанарын багт хэлэлцүүлэн шийдвэр гаргалтуудыг хийж байна.</p> |
| | <p><i>Хүний нөөц, сургалт хөгжил</i></p> | <p>31 эрэгтэй, 55 эмэгтэй, нийт 81 ажиллагсадтай. Үүнээс үндсэн үйл ажиллагаа хариуцсан 32 ажилтан, 49 аж ахуй болон үйлдвэрийн ажилчидтай. Дээд боловсролтой 32, магистр 5, бакалаврын боловсролтой 27, мэргэшсэн нягтлан бодогч 1, хөгжлийн бэрхшээлтэй 2 ажилтан, ажиллагсдын дундаж нас 35, ажилласан дундаж хугацаа 5 жил, 24 удаагийн 24 цагийн сургалт хийсэн. Хагас жилд 28 ажилтан ажилд орсноос 18 ажилтан ажлын байран дээрээ дадлагажиж жинхэлсэн, 5 оюутан үйлдвэрлэлийн дадлага хийсэн байна. Ажиллагсдын амралтын өрөөний тохижилт хийгдсэн.</p> |




2018 оноос чацарганы 100 га талбайд хөдөө аж ахуйн зохистой дадал олон улсын GLOBAL GAP стандарт, 2022 онд Европын холбоонд “Увсын чацаргана” газар зүйн заалтыг бүртгүүлээд байна.

Газар тариалангийн үйл ажиллагаа



Чацарганы талбайд чацарганы модны таналт, тайралт, өнжмөл өвс хадах, шижим устгах, усалгааны шуудуу цэвэрлэх, усалгаа хийх зэрэг арчилгаа болон чацарганы 800 ширхэг модны нөхөн тарилт, бойжуулгын талбайд хүлэмжээс үрсэлгээ шилжүүлэх, бойжуулгын талбайн модны зэрлэг устгах, үрсэлгээний хүлэмжний хөрс бэлтгэх ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

| | | |
|--|---|--|
| | |  |
| | <p><i>Бизнесийн тасралтгүй үйл ажиллагаа, гадаад харилцаа</i></p> | <ol style="list-style-type: none"> 1. Увсын чацаргана газарзүйн заалтыг МУ-аас анх удаа Европын холбоонд амжилттай бүртгүүлсэн 2. Дэлхийн банкнаас санхүүжүүлж буй “Экспортыг дэмжих төсөл”-ын Түншлэлийн хөтөлбөрт хамрагдан ажиллаж байна. 3. EU day 2022 арга хэмжээнд амжилттай оролцсон. 4. Компанийн бараа бүтээгдэхүүний түүхий эд, бараа материалын захиалгыг тогтмол БНХАУ, ХБНГУ, ОХУ-аас авч ажилласан. |
| | <p><i>Нийгмийн хариуцлага</i></p> | <p>Ажиллагсадын гэр бүлд шинээр мэндэлсэн хүүхдэд 300,000 төгрөгийн хадгаламж нээж, 24 хүүхэд хадгаламжтай боллоо.</p> <p>3 сарын 26-ны Хөнгөн хүнсний салбарын ажилтны баярыг тохиолдуулж Гар бөмбөгийн тэмцээн харилцагч байгууллагуудын дунд зохион байгууллаа.</p> |




Хамт олон, нийтийн арга хэмжээнд 5,900,000 төгрөгийн зарцуулав.



Алтан гартаа ангаах увидастай, ариунхан сэтгэлдээ авралын тэнгэртэй Увс аймгийн эмч, сувилагч нарын баярын арга хэмжээнд оролцов.



| | | |
|--|--|--|
| | | <p>Хүүхэд, залуучуудын сайн сайхан, гэгээлэг ирээдүйн төлөөх сайн үйлсэд нэгдэж буй залуусын Тоонот 21x21 төсөлд Увс аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран Хүүхдийн тусламжийн 108 утсыг орон даяар таниулах, сурталчлах зорилготой аялан тоглолтыг дэмжиж оролцов.</p> |
|--|--|--|



Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Л.Н.  ХК-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг: 

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Б.Болормаа

Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг: 